



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
АРВАЙХЭЭР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 05

Арвайхээр

Арвайхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурал, Ажлын албаны бүтэц, орон тоо  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Арвайхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Ажлын албаны 2022 онд ажиллах бүтэц, орон тоог хавсралтаар батласугай.

2. Байгууллагын бүтэц, орон тооны цалин, урамшууллыг холбогдох хууль, дүрэм журмыг баримтлан 2022 оны төсөвт батлуулан ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Тунгалаг/, Нягтлан бодогч /Н.Наранчимэг/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

ДАРГА  ДОНЬДДОРЖ



Арвайхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2024 оны 12 дугаар сарын 29-ны  
өдрийн 65 дугаар тогтоолын хавсралт

АРВАЙХЭЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
АЖЛЫН АЛБАНЫ 2022 ОНД АЖИЛЛАХ БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаалын нэр	Албан тушаалын тоо	Хууль эрх зүйн үндэслэл, тайлбар
1	2	3	4
Нэг. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал			
1.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Төлөөлөгчид, Зөвлөл	Төлөөлөгчид 31 Зөвлөл 7	ЗЗНДНТУ-ын тухай хуулийн 10.3.4, 23.5 дахь заалт
2.	Иргэдийн Нийтийн Хурал, Хурлын дарга	13	ЗЗНДНТУ-ын тухай хуулийн 38.6 дахь заалт. Багийн Засаг даргын үндсэн цалингийн хувиар урамшуулал олгох
Хоёр. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба			
1.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга	1	Засгийн газрын тогтоолыг баримтлан цалин тогтоох
2.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын зөвлөх	1	Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйл, 11.2, 11.3 дахь заалт. Засгийн газрын холбогдох шийдвэр, Арвайхээр сумын ИТХ-ын 2021-2024 оны стратеги
3.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга	1	Засгийн газар, Төрийн албаны зөвлөлийн тогтоол, шийдвэрийг баримтлан цалин тогтоох
4.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зохион байгуулалт, дотоод ажил хариуцсан ажилтан	1	ЗЗНДНТУ-ын тухай хуулийн 20.3, Төсвийн тухай хуулийн 16.5.3 дахь заалт, "Арвайхээр сумын ИТХ-ын 2021-2024 оны стратеги" төлөвлөгөө, Засгийн газар, Төрийн албаны зөвлөлийн тогтоол, шийдвэрийг баримтлан цалин тогтоох
5.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын олон нийттэй харилцах, хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан	1	ЗЗНДНТУ-ын тухай хуулийн 20.3, Төсвийн тухай хуулийн 16.5.3 дахь заалт, "Арвайхээр сумын ИТХ-ын 2021-2024 оны стратеги" төлөвлөгөө, Засгийн газар, Төрийн албаны зөвлөлийн тогтоол, шийдвэрийг баримтлан цалин тогтоох
6.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Архив, бичиг хэргийн ажилтан	1	ЗЗНДНТУ-ын тухай хуулийн 20.3, Төсвийн тухай хуулийн 16.5.3 дахь заалт, "Арвайхээр сумын ИТХ-ын 2021-2024 оны стратеги" төлөвлөгөө, Архив, албан хэрэг хөтлөлийн тухай (шинэчилсэн найруулга) хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газар, Төрийн албаны зөвлөлийн тогтоол, шийдвэрийг баримтлан цалин тогтоох
7.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын жолооч	1	Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан цалин тогтоох
8.	ИТХ-ын нягтлан бодогч	0.5	Хавсран гүйцэтгэгч, Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан цалин тогтоох